



ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД С.ЧИНЗОРИГ
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас/факс: (976-51) 26-74-68, <http://www.mof.gov.mn>

2020.11.25 № 4-1/2245
танай _____ -ны № _____ -т

Монгол Улсын 2020 оны төсөв
хүргүүлэх тухай

Монгол Улсын 2020 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2020 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2020 оны төсвийн тухай хуулийн төслүүд Улсын Их Хурлын 2019 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар батлагдлаа.

Монгол Улсын Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлого 11,797.8 тэрбум төгрөг буюу Дотоодын нийт бүтээгдэхүүн /ДНБ/-ий 29.0 хувь, тэнцвэржүүлсэн орлогод нийцүүлсэн нэгдсэн төсвийн нийт зарлага 13,872.6 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 34.1 хувь, нэгдсэн төсвийн нийт тэнцэл 2,074.7 тэрбум төгрөгийн алдагдалтай буюу ДНБ-ий -5.1 хувьтай байхаар тус тус төлөвлөлөө.

Монгол Улсын 2020 оны төсвийн гүйцэтгэлийг зохион байгуулах, төсвийн сар, улирлын хуваарийг боловсруулах ажлын хүрээнд тухайн төсвийн жилийн онцлог, анхаарах зүйлс, төсвийн хуваарийг боловсруулах удирдамжийг үүгээр хүргүүлж байна.

Монгол Улсын 2020 оны төсвийн сар, улирлын хуваарийг дараах зарчмыг баримтлан боловсруулна. Үүнд:

1. Төсвийн орлогыг төвлөрүүлэгч байгууллагуудын хувьд төсөвт төвлөрүүлэх орлогын хуваарийг боловсруулахдаа Сангийн яамнаас боловсруулсан 2020 оны макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд болон тухайн орлогод нөлөөлөгч гол хүчин зүйлийн талаарх төсөөлөлтэй уялдуулж, тухайн орлогын улирлын шинж чанарын нөлөөллийг тусган тооцох;
2. Төсвийн орлого төвлөрүүлэх хуваарийг боловсруулахдаа өмнөх жилүүдийн гүйцэтгэл, орлогын төлөвлөгөөний биелэлтэд үндэслэн төлөвлөх;
3. Аливаа арга хэмжээний зардлын хуваарийг боловсруулахдаа байгууллагын үйл ажиллагаа, төлөвлөгөөтэй уялдуулан хэвийн явуулах зорилгоор оны эхнээс оновчтой жигд хуваарилах;
4. Батлагдсан төсвийн орлого, зарлагын сар, улирлын хуваарилалтыг хийхдээ жилийн төлөвлөгөөтэй тэнцүү байхаар боловсруулах;
5. Өр, төлбөр үүсгэхгүй байх нөхцөлийг хангах;
6. Түлш халаалтын зардлыг хуваарилахдаа тухайн орон нутгийн онцлог, халаалтын улирал болон түлш бэлтгэх хугацааг харгалзах;
7. Төсөвт байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогоор санхүүжих зардлын хуваарийг тухайн орлогын хуваарьтай уялдуулах;
8. Шинээр батлагдсан хууль, эрх зүйн актыг хэрэгжүүлэхэд анхаарах;

782970